



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026. 02. 06 № 05/89.
танай _____-ны № _____-т


Тайлан хүргүүлэх тухай

Харьяа байгууллагуудын 2025 оны 4 дүгээр улирлын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг хүргүүлж байна.

Нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д 2026 оны 01 дүгээр улирлын мэдээг үнэн зөв, бүрэн оруулж 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор зөвлөмжийн биелэлтийг ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ОЮУНБИЛЭГ

1520020132

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
“НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ хийх үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам”-ын 4.1-д “Мэдээлэл хариуцагч өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод байдлыг энэ журмын 3 дугаар зүйлд заасан аргачлалаар үнэлж”, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2025 оны 04 дүгээр улирлын мэдээнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой.

Хоёр. Ажлын хамрах хүрээ, бүрэлдэхүүн

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу салбарын 26 байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, олон нийтэд түгээсэн мэдээ, тайланг нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д үнэн зөв, бүрэн оруулсан эсэхэд Хяналт, дотоод аудитын хэлтсийн Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Наранчимэг 2025 оны 04 дүгээр улирлын мэдээлэлд хяналт шинжилгээ хийж ажиллаа.

Гурав. Мэдээлэл байршуулах хууль эрх зүйн орчин

3.1 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Нийтийн мэдээлэл хариуцагч төрийн байгууллага нь нээлттэй мэдээллийг тогтмол хугацаандаа шинэчлэн хуулийн 8.1-д “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалтай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэсний дагуу эдгээр мэдээллийг хуулийн 8.2.-8.6-д заасан зүйл заалт бүрээр өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтлэн, шинэчилнэ.

Хуулийн 8.8-д Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана;

Хуулийн 8.9-д Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг улирал, хагас жил, жилээр гаргах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сард багтаан бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд байршуулна;

Хуулийн 8.11-д Мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван өдрийн дотор өөрчлөлтийг тусгаж, мэдээллийг шинэчлэн нийтэлнэ” гэж тус тус заасныг баримтлан ажиллах.

3.2 Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”.

Журмын дагуу мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцах ажилтныг (цаашид “эрх бүхий ажилтан” гэх) томилон ажиллуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина. Эрх бүхий ажилтан нь цахим хуудсанд байршуулж нийтлэх нээлттэй мэдээллийн үнэн зөв байдлыг хангана. Нийтийн мэдээлэл хариуцагч нь дотоод журам батлан мөрдүүлж болно. Эсвэл мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан өөрт хамаарах нээлттэй мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж, “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага” Монгол Улсын MNS 6285:2017” стандартыг хангасан, Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)-д нийцсэн өөрийн цахим хуудас (цаашид “цахим хуудас” гэх)-д байршуулж нийтэлнэ.

3.3 Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”

Мэдээллийн хүртээмжтэй байдал (МХБ) - Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх, хангалттай буюу 30 оноо, дутуу буюу зөвхөн цахим хуудаст нийтэлсэн бол 15 оноо, мэдээллийн самбарт нийтэлсэн бол 10 оноо, бусад хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол 5 оноо, хангалтгүй буюу 0 оноо;

- Хугацаандаа нийтлэгдсэн байдал (ХНБ) - нээлттэй мэдээллийг Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д -д заасан хугацаанд олон нийтэд хүргэсэн эсэх, хуулийн хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол хангалттай буюу 30 оноо, хуулийн хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол дутуу буюу 10 оноо, нээлттэй мэдээллийг нийтлээгүй, шинэчлээгүй бол хангалтгүй буюу 0 оноо;

- Мэдээллийн бүрэн бүтэн байдал (МБББ) - нээлттэй мэдээллийг Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8.2- 8.6-д -д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх, /хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 10 оноо, хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 5 оноо; нийтлээгүй бол 0 оноо/;

- Эх сурвалжийн тодорхой байдал (ЭСТБ) - Нийтийн ил тод байдлын тухай хуулийн нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх, /нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол хангалттай буюу 30 оноо; дутуу бол 10 оноо, хангалтгүй бол 0 оноо/.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 26 байгууллага Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (www.shilen.gov.mn)-д мэдээгээ оруулсан. Нийт орсон мэдээнд мэдээлэл түгээх үйл ажиллагааны зохион байгуулалт, хүртээмж, хуульд нийцсэн байдал зэрэгт хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дунджаар 81 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын ЦУОШГ, харьяа 25 байгууллагын үнэлгээ

Д/д	Байгууллагын нэр	2025 оны I улирал	2025 оны II улирал	2025 оны III улирал	2025 оны IV улирал
1	Цаг уур, орчны шинжилгээний газар	0%	73%	43.3%	80%
2	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	0%	0%	0%	82%
3	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	0%	42%	0%	81%
4	Нислэгийн цаг уурын төв	0%	0%	0%	66%
5	Улаанбаатар УЦУОШТ	0%	0%	0%	34%
6	Архангай УЦУОШТ	30%	63%	56%	91%
7	Баян-Өлгий УЦУОШТ	0%	63%	83%	91%
8	Баянхонгор УЦУОШТ	0%	0%	0%	53%
9	Булган УЦУОШТ	0%	69%	73%	87%
10	Говь-Алтай УЦУОШТ	0%	62%	60%	80%
11	Говьсүмбэр УЦУОШТ	83%	97%	95%	97%
12	Дархан-Уул УЦУОШТ	65%	80%	81%	86%
13	Дорноговь УЦУОШТ	90%	99%	98%	100%
14	Дорнод УЦУОШТ	0%	70%	64%	75%
15	Дундговь УЦУОШТ	96%	95%	95%	98%
16	Завхан УЦУОШТ	72%	70%	63%	52%
17	Орхон УЦУОШТ	0%	87%	88%	97%
18	Өвөрхангай УЦУОШТ	0%	71%	72%	99%
19	Өмнөговь УЦУОШТ	0%	71%	69%	70%
20	Сүхбаатар УЦУОШТ	98%	93%	90%	98%
21	Сэлэнгэ УЦУОШТ	97%	76%	85%	100%
22	Төв УЦУОШТ	0%	64%	81%	70%
23	Увс УЦУОШТ	0%	61%	60%	96%
24	Ховд УЦУОШТ	0%	64%	90%	90%
25	Хөвсгөл УЦУОШТ	51%	0%	97%	95%
26	Хэнтий УЦУОШТ	50%	54%	0%	45%
	УЦУОШ-ний салбарын дундаж хувь	28%	59%	59%	81%

4.1. Мэдээллийн хүртээмжтэй байдал /МХБ/. Нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн байх. Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг бүрэн дүүрэн тусгаагүй, хүний нөөцийн стратеги, төлөвлөлт түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, албан тушаалын тодорхойлолт дутуу, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны баримт бичиг, үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээний хөлс, төлбөр төлөх дансны мэдээлэл бүрэн оруулаагүй.

4.2. Хугацаандаа нийтэлсэн байдал /ХНБ/. Нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн байх. Цахим хуудасны мэдээллийг тухай бүр шинэчлээгүй. Өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд улирал бүр өөрчлөлт, шинэчлэлтийг тогтмол хийгээгүй. Бүтцийн өөрчлөлтийн зарим мэдээлэл, ажлын байрны сул орон тоо, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээ, тендерийн баримт бичиг, төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар мэдээллийг шинэчлэн хугацаандаа хийх.

4.3. Мэдээллийн бүрэн бүтэн байдал /МБББ/. Хуулийн 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн байх. Тухайн мэдээллийн зөв линкийг холбох, тухайн мэдээллийн pdf файлыг оруулах, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан зураг зэргийг бүх мэдээлэлд оруулах.

4.4. Эх сурвалжийн тодорхой байдал /ЭСТБ/. Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн байх. Өөрсдийн веб сайт дээр мэдээллийг оновчтой байрлуулах, “Ил тод байдал” гэсэн тусгай цэс үүсгэсэн ч хуульд заасан шаардлагатай мэдээллийг нэг дор төвлөрүүлээгүй. Хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар хайлт хийх боломжтой байхаар зохион байгуулж мэдээлэлд холбогдох ажилтны нэр, цахим шуудан, эх сурвалжийг тодорхой бичиж оруулаагүй байна.

2025 оны 4 дүгээр улирлын мэдээнд “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу 4 шалгуур үзүүлэлтийн дундаж оноог нэгтгэв (Хүснэгт 2).

д/д	Байгууллагын нэр	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилт /%/	Тайлбар
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ		
1	ЦУОШГ	23	24	24	23	80	6 мэдээлэл 0 оноо авсан
2	УЦУОСМХ	26	30	25	14	82	эх сурвалж тодорхой бичих
3	БОХЗТЛ	28	30	28	12	81	эх сурвалж тодорхой бичих
4	Нислэгийн цагуурын төв	22	25	25	22	66	7 мэдээлэл 0 оноо, мэдээлэл бүрэн биш
5	Улаанбаатар	7	10	7	3	34	20 мэдээлэл 0 оноо авсан
6	Архангай	27	30	27	27	91	
7	Баян-Өлгий	27	29	27	29	91	
8	Баянхонгор	7	27	14	18	53	7 мэдээлэл 0 оноо, файл, зураг, нээлттэй байршуулах
9	Булган	26	30	28	25	87	
10	Говь-Алтай	23	30	20	21	80	эх сурвалж тодорхой бичих
11	Говьсүмбэр	29	30	29	30	97	
12	Дархан-Уул	29	30	30	12	86	эх сурвалж тодорхой бичих
13	Дорноговь	30	30	30	30	100	
14	Дорнод	18	30	26	19	75	дэлгэцийн зураг оруулахгүй, эх сурвалж тодорхой бичих
15	Дундговь	30	30	28	30	98	
16	Завхан	15	27	10	11	52	дэлгэцийн зураг оруулахгүй, эх сурвалж тодорхойгүй
17	Орхон	29	29	29	29	97	1 мэдээлэл 0 оноо авсан
18	Өвөрхангай	30	30	30	30	99	
19	Өмнөговь	22	25	19	12	70	6 мэдээлэл 0 оноо, эх сурвалж бичих
20	Сүхбаатар	28	30	30	30	98	
21	Сэлэнгэ	30	30	30	30	100	
22	Төв	14	21	17	23	70	2 мэдээлэл 0 оноо авсан
23	Увс	27	27	27	27	96	1 мэдээлэл 0 оноо авсан
24	Ховд	24	30	30	24	90	
25	Хөвсгөл	27	30	29	29	95	
26	Хэнтий	13	22	8	9	45	8 мэдээлэл 0 оноо авсан. бүрдэл дутуу, эх сурвалж бичих
Дундаж		24	28	24	22	81	

Тав. Дүгнэлт

1. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 26 байгууллага Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (www.shilen.gov.mn)-д мэдээ оруулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээний дүнгээр 81% байгаа нь жилийн дүнгээс 22%-ийн өсөлттэй байна.

2. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn, www.shilen.gov.mn, байгууллагын веб хуудаст мэдээ мэдээлэл оруулах албан тушаалтан томилон ажиллуулах, томилогдсон албан тушаалтан мэдээллийн бүрдэл, агуулгыг шалгаж хугацаандаа шинэчлэн бүрэн оруулаж хэвших хэрэгтэй. Нийт байгууллагын мэдээнд мэдээллийн хүртээмжтэй байдал, тогтмол хугацаандаа шинэчилсэн эсэх, бүрэн бүтэн байдал болон эх сурвалжийн тодорхой оруулсан эсхийг улирал бүр шалгаж нээлттэй мэдээллийн үнэлгээнд оноо өгч хувиар дүгнэдэг.

3. Цаг уур, орчны шинжилгээний газрын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт 2023 онд 93,7%-тай үнэлэгдэж байсан бол 2024 онд мэдээлэл огт оруулаагүй 0%-тай, 2025 оны 1 дүгээр улиралд 0%, 2 дугаар улиралд 73.6%, 3 дугаар улиралд 43.3%, 4 дүгээр улиралд 80%-тай дүгнэгдсэн.

4. Салбарын бүх байгууллага 2025 оны 4 дүгээр улиралд мэдээллээ оруулсан. Мэдээлэл нь тухайн байгууллагат хамааралгүй тохиолдолд “Холбоо хамааралгүй” гэж холбогдох хуулийн тайлбар бичээгүй, өмнөх улиралд мэдээлэл оруулж байгаад хамааралгүй гэж тайлбар хийсэн тохиолдолд “Нээлттэй байршуулаагүй” гэж 0 оноо авч үнэлгээ буурсан. Үүнд: Улаанбаатар хотын УЦУОШТ 20, Хэнтий 8, Нислэгийн цаг уурын төв 7, Баянхонгор 7, ЦУОШГазар 6, Өмнөговь 2, Төв 2, Орхон 1, Увс 1 удаа 0 оноо авсан.

Зургаа. Зөвлөмж

1. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу байгууллага тус бүр Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээллийг байгууллагын цахим хуудас, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn, www.shilen.gov.mn-д тогтмол хугацаанд нь байршуулан 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор 1 дүгээр улирлын мэдээллийг шинэчлэн 100% бүрэн оруулж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах;

2. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээллийг улирал бүр шинэчлэх, өөрчлөлт орсон даруй тухай бүр мэдээллийг тогтмол шинэчлэн оруулах, цахим хуудасны хандалтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хайх боломжийг хялбаршуулах;

3. Хуульд заасан мэдээллийн ангиллыг бүрэн тусгаж, хяналтын жагсаалтаар шалгах;

4. Мэдээлэл оруулах ажилтны эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;

5. Мэдээлэл хариуцагч байгууллагууд нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хуулийн заалт бүрээр задалсан 87 нэр төрлийн мэдээнээс өөрт хамаарал бүхий мэдээллийг бүх талбарт холбоос үзэх, файл үзэх, зураг үзэх гэсэн 3 хэлбэрээр оруулах, хамааралгүй мэдээллийг холбоо хамааралгүй тухай хуулийн заалтыг бичих.